

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Соёл урлагийн газрын 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: СНАГ-2023/200/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn Улаанбаатар хот 2023 он	Санхүү, нийцлийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор: Ц.НАРАНЧИМЭГ Утас: 261663 Цахим хаяг: naranchimegts@audit.gov.mn Аудитын менежер: Д.ЭНХДАЛАЙ Утас: 260512 Цахим хаяг: enkhdalaid@audit.gov.mn Аудитор: Ч.ДАШДАВАА Утас: 261740 Цахим хаяг: dashdavaach@audit.gov.mn Аудитыг гэрээгээр гүйцэтгэсэн: "Шинэ их тэрбум аудит" ХХК Захирал: Д.ДАШДУЛАМ Утас: 9910-8039 Цахим хаяг: ikhterbum@gmail.com
---	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу



СОЁЛ УРЛАГИЙН ГАЗРЫН
ДАРГА Н.МӨНХЗУЛ ТАНАА

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:51-26-42-30
E-mail: info@audit.gov.mn

2023.02.24 № 07/416
танай _____-ны № _____-т

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, 8.4, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Соёл урлагийн газрын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан буруу илэрхийлэл нь материаллаг боловч өргөн тархаагүй гэж үзсэн бөгөөд санхүүгийн тайланд үзүүлэх нөлөөг эс тооцвол Соёл урлагийн газрын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн зөрчлүүд нь бидний тогтоосон 85,505.3 мянган төгрөгийн материаллаг байдлын түвшнээс өндөр бөгөөд Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1, 6 дугаар зүйлийн 6.1, 6.4.1, 6.4.8, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.4, 13.5, 13.7, Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.1, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 72 дугаар зүйлийн 72.4, 73 дугаар зүйлийн 73.4, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.5, 17 дугаар зүйлийн 17.1, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.4, Хөдөлмөрийн тухай хуулийн 110.2-д заасныг хэрэгжүүлж ажиллаагүй, санхүүгийн тайлагналын үнэн зөв, иж бүрэн байх, оршин байх, эрх ба үүрэг, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Асуудлын онцолсон хэсэг

“Алсын хараа-2050” Монгол улсын урт хугацааны хөгжлийн бодлогын хүрээнд Монгол улсыг дэлхийн нүүдэлчдийн соёл иргэншлийн төв болгох зорилгоор “Нүүдэлчдийн соёл, спортын их наадам”-ыг тогтмол зохион байгуулах гэсэн зорилттой уялдуулан Соёлын яам, Соёл урлагийн газар хамтарч Горхи-Тэрэлжийн байгалийн цогцолбор газарт “Нүүдэлчин” дэлхийн соёлын фестиваль зохион байгуулсан байна.

Z:\Yawsan_Bichig\2023\0224 SNAG-52 Docx

0001050700

Соёлын биет бус өвийн үзлэг, бүсчилсэн судалгааг орон даяар зохион байгуулж цахим үзлэг, судалгаанд 21 аймаг, 9 дүүргийн нийт 8,142 өвлөн уламжлагч хамрагдсан байна.

Аудитын гол асуудал

Нэмэлт санхүүжилтийн дансанд дээд шатны төсвийн захирагчийн эрх шилжүүлэх тушаалаар “Үндэсний их баяр наадам”-ын үйл ажиллагааг зохион байгуулахад 4,018,955.0 мянган, “Үндэсний бичиг соёл, номын өдрүүд-2022” арга хэмжээ зохион байгуулахад 300,000.0 мянган, “Нүүдэлчин монгол-2022 соёлын биет бус өвийн их наадам”-ыг санхүүжилтэд 2,149,955.0 мянган, “Соёлын орчин, орон зайг бүрдүүлж хөгжүүлэх, бий болгох” хөтөлбөрийг санхүүжүүлэхэд 200,000.0 мянган, “Соёлын биет бус өвийн бүсчилсэн судалгаа” хийхэд 210,000.0 мянган, соёлын бусад арга хэмжээг зохион байгуулахад 255,800.0 мянган, өмнөх онд дутуу хэрэгжүүлсэн хөтөлбөр, арга хэмжээний санхүүжилтийн 743,643.0 мянган төгрөг, нийт 7,878,353.0 мянган төгрөгийн орлого бүрдүүлж, 11 хөтөлбөрийн 24 арга хэмжээг хэрэгжүүлэхэд 7,610,381.9 мянган төгрөгийг зарцуулсан байна.

Бусад асуудлын хэсэг

Байгууллагын жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 20 зорилтын хүрээнд 60 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс 88.0 хувийн гүйцэтгэлтэй гэж тайлагнасан байна. Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

САНХҮҮ-НИЙЦЛИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

 Ц.НАРАНЧИМЭГ



Z:\Yawsan_Bichig\2023\0224 SNAG-52.Docx

Хоёр. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>752,304,409.00</u>	<u>148,574,175.32</u>
33	АВЛАГА	743,643,000.00	93,300,000.00
33300	Татаас, санхүүжилтийн авлага	743,643,000.00	93,300,000.00
35	БАРАА МАТЕРИАЛ	8,661,409.00	55,274,175.32
354	Хангамжийн материал	8,661,409.00	55,274,175.32
35410	Бичиг хэргийн материал	1,797,260.00	1,732,225.32
35420	Аж ахуйн материал	4,809,449.00	33,538,050.00
35470	Бусад хангамжийн материал	2,054,700.00	20,003,900.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>56,807,390.72</u>	<u>62,165,636.16</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	56,807,390.72	62,165,636.16
392	Биет хөрөнгө	56,773,015.86	62,165,636.16
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	93,194,282.28	103,317,882.28
39206	Хуримтлагдсан элэгдэл	(56,525,403.78)	(69,481,270.84)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	46,027,728.74	57,127,728.74
39208	Хуримтлагдсан элэгдэл	(25,923,591.38)	(28,798,704.02)
393	Биет бус хөрөнгө	34,374.86	00.00
39301	Програм хангамж	1,155,000.00	1,155,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(1,120,625.14)	(1,155,000.00)
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>809,111,799.72</u>	<u>210,739,811.48</u>
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	<u>1,933,852.47</u>	<u>4,848,966.22</u>
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	1,933,852.47	4,848,966.22
413	Өглөг	1,933,852.47	4,848,966.22
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	00.00	2,915,113.75
4136	Бусад өглөг	1,933,852.47	1,933,852.47
41361	Байгууллагад төлөх өглөг	1,933,852.47	1,933,852.47
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>807,177,947.25</u>	<u>205,890,845.26</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	807,177,947.25	205,890,845.26
512	Хуримтлагдсан үр дүн	807,177,947.25	205,890,845.26
51210	Өмнөх үеийн үр дүн	81,691,193.26	807,177,947.25
51220	Тайлант үеийн үр дүн	725,486,753.99	(601,287,101.99)
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>809,111,799.72</u>	<u>210,739,811.48</u>

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	2,399,101,900.00	7,949,243,200.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	2,214,400.00	5,343,600.00
120	Нийтлэг татварын бус орлого	2,214,400.00	5,343,600.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	2,214,400.00	5,343,600.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	560,000.00	420,000.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	1,654,400.00	4,923,600.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	2,396,887,500.00	7,943,899,600.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	565,653,600.00	809,189,600.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	565,653,600.00	809,189,600.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	1,831,233,900.00	7,134,710,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	1,831,233,900.00	7,134,710,000.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	1,673,615,146.01	8,550,530,301.99
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,673,615,146.01	8,550,530,301.99
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,527,143,947.73	8,330,187,661.06
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	203,252,807.02	265,013,202.19
210101	Үндсэн цалин	192,241,221.30	217,618,561.12
210102	Нэмэгдэл	11,011,585.72	18,058,625.40
210103	Унаа хоолны хөнгөлөлт	00.00	29,336,015.32
210104	Урамшуулал	00.00	00.35
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	26,828,819.94	32,924,155.91
210201	Тэтгэврийн даатгал	18,559,908.72	23,208,853.65
210202	Тэтгэмжийн даатгал	2,105,299.13	2,447,900.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,644,238.01	1,812,944.93
210204	Ажилгүйдлийн даатгал	408,776.86	450,441.43
210205	Эрүүл мэндийн даатгал	4,110,597.22	5,004,015.90
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	00.00	43,209,800.00
210304	Байрны түрээс	00.00	43,209,800.00
2104	Хангамж, бараа материалын зардал	36,999,229.09	37,112,013.72
210401	Бичиг хэрэг	13,698,600.00	24,306,337.00
210402	Тээвэр, шатахуун	14,072,000.00	1,624,250.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	7,744,569.09	9,463,969.72
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,484,060.00	1,717,457.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	39,000.00	19,528,000.00
210604	Урсгал засвар	00.00	19,528,000.00
2107	Томилолт, зочны зардал	676,000.00	16,049.00
210702	Дотоод албан томилолт	676,000.00	00.00
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах	00.00	16,049.00

2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,203,718,880.00	7,888,620,285.68
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,196,718,880.00	7,885,737,385.68
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	7,000,000.00	2,882,900.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	55,629,211.68	43,764,154.56
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	39,376,000.00	27,898,800.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	16,253,211.68	15,865,354.56
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	146,471,198.28	220,342,640.93
2132	Бусад урсгал шилжүүлэг	6,567,500.00	45,318,800.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	00.00	44,918,800.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	6,567,500.00	400,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	97,163,058.28	352,723.93
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	97,163,058.28	352,723.93
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	42,740,640.00	174,671,117.00
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	42,740,640.00	174,671,117.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	<u>725,486,753.99</u>	<u>(601,287,101.99)</u>
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	<u>725,486,753.99</u>	<u>(601,287,101.99)</u>

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	<u>2,406,283,920.00</u>	<u>8,687,962,600.00</u>
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	560,000.00	420,000.00
120	Нийтлэг татварын бус орлого	560,000.00	420,000.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	560,000.00	420,000.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	560,000.00	420,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	2,405,723,920.00	8,687,542,600.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	565,653,600.00	809,189,600.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	565,653,600.00	809,189,600.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	1,840,070,320.00	7,878,353,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	1,831,233,900.00	7,878,353,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	8,836,420.00	00.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	2,405,224,620.00	<u>8,671,662,600.00</u>
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,405,224,620.00	8,671,663,400.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,515,110,421.72	8,358,019,959.07
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	202,041,278.87	264,423,444.35

210101	Үндсэн цалин	151,668,749.94	171,912,785.81
210102	Нэмэгдэл	50,372,528.93	52,327,720.17
210103	Унаа хоолны хөнгөлөлт	-	35,871,292.37
210104	Урамшуулал	-	4,311,646.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	27,963,513.76	30,598,800.00
210201	Тэтгэврийн даатгал	19,190,428.34	20,807,200.00
210202	Тэтгэмжийн даатгал	2,215,890.63	2,447,900.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,749,115.39	1,958,300.00
210204	Ажилгүйдлийн даатгал	435,096.16	489,600.00
210205	Эрүүл мэндийн даатгал	4,372,983.24	4,895,800.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	-	43,209,800.00
210304	Байрны түрээс	-	43,209,800.00
2104	Хангамж, бараа материалын зардал	23,738,189.09	19,951,632.00
210401	Бичиг хэрэг	3,610,600.00	3,030,700.00
210402	Тээвэр, шатахуун	11,397,400.00	1,624,250.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	7,837,629.09	9,098,312.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	892,560.00	6,198,370.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	978,400.00	20,242,000.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	978,400.00	244,000.00
210604	Урсгал засвар	-	19,998,000.00
2107	Томилолт, зочны зардал	676,000.00	265,000.00
210702	Дотоод албан томилолт	676,000.00	265,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,216,686,880.00	7,891,160,082.72
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,209,686,880.00	7,885,277,182.72
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	7,000,000.00	5,882,900.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	43,026,160.00	88,169,200.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	43,026,160.00	88,169,200.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	890,114,198.28	313,643,440.93
2132	Бусад урсгал шилжүүлэг	6,567,500.00	45,318,800.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	-	44,918,800.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	6,567,500.00	400,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	97,163,058.28	353,523.93
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	97,163,058.28	353,523.93
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	786,383,640.00	267,971,117.00
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	786,383,640.00	267,971,117.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	<u>1,059,300.00</u>	<u>16,300,000.00</u>
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	1,059,300.00	16,300,000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	1,059,300.00	16,300,000.00
2200	Дотоод эх үүсвэрээр	1,059,300.00	16,300,000.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	1,059,300.00	16,300,000.00

6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	<u>(1,059,300.00)</u>	<u>(16,300,000.00)</u>
7	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	≡	≡
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	-	-
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	-	-	81,6391,193.26	81,6391,193.26
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	-	-	25,220,108.77	25,220,108.77
C07	Тайлант үеийн үр дүн	-	-	725,486,753.99	725,486,753.99
C08	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	-	-	807,177,947.25	807,177,947.25
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	-	-	807,177,947.25	807,177,947.25
D08	Тайлант үеийн үр дүн	-	-	(601,287,101.99)	(601,287,101.99)
D09	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	-	-	205,890,845.26	205,890,845.26

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	809,190,400.00	808,836,876.07	353,523.93	99.9
21	УРСГАЛ ЗАРДАЛ	809,190,400.00	808,836,876.07	353,523.93	99.9
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	763,780,400.00	763,518,076.07	262,323.93	99.9
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	244,790,900.00	264,423,444.35	(19,632,544.35)	108.0
210101	Үндсэн цалин	174,468,000.00	171,912,785.81	2,555,214.19	98.5
210102	Нэмэгдэл	70,322,900.00	52,327,720.17	17,995,179.83	74.4
210103	Унаа хоолны хөнгөлөлт	-	35,871,292.37	(35,871,292.37)	-
210104	Урамшуулал	-	4,311,646.00	(4,311,646.00)	-
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	30,598,800.00	30,598,800.00	-	100.0
210201	Тэтгэврийн даатгал	20,807,200.00	20,807,200.00	-	100.0
210202	Тэтгэмжийн даатгал	2,447,900.00	2,447,900.00	-	100.0
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,958,300.00	1,958,300.00	-	100.0
210204	Ажилгүйдлийн даатгал	489,600.00	489,600.00	-	100.0
210205	Эрүүл мэндийн даатгал	4,895,800.00	4,895,800.00	-	100.0
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	43,209,900.00	43,209,800.00	100.00	100.0
210304	Байрны түрээс	43,209,900.00	43,209,800.00	100.00	100.0
2104	Хангамж, бараа материалын зардал	15,201,700.00	19,951,632.00	(4,749,932.00)	131.2
210401	Бичиг хэрэг	1,486,300.00	3,030,700.00	(1,544,400.00)	203.9
210402	Тээвэр, шатахуун	6,243,400.00	1,624,250.00	4,619,150.00	26.0
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	5,230,100.00	9,098,312.00	(3,868,212.00)	174.0
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,241,900.00	6,198,370.00	(3,956,470.00)	276.5
2106	Эд хогшил худалдан авах	25,008,400.00	20,242,000.00	4,766,400.00	80.9
210601	Багаж, техник, хэрэгсэл	5,008,400.00	244,000.00	4,764,400.00	4.9
210604	Урсгал засвар	20,000,000.00	19,998,000.00	2,000.00	100.0
2107	Томилолт, зочны зардал	265,000.00	265,000.00	-	100.0
210702	Дотоод албан томилолт	265,000.00	265,000.00	-	100.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	316,535,100.00	296,658,199.72	19,876,900.28	93.7
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	310,652,200.00	290,775,299.72	19,876,900.28	93.6
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	5,882,900.00	5,882,900.00	-	100.0

2109	Бараа үйлчилгээний бусад зардал	88,170,600.00	88,169,200.00	1,400.00	100.0
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	88,170,600.00	88,169,200.00	1,400.00	100.0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	45,410,000.00	45,318,800.00	91,200.00	99.8
2132	Бусад урсгал шилжүүлэг	45,410,000.00	45,318,800.00	91,200.00	99.8
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, дэмжлэг	45,000,000.00	44,918,800.00	81,200.00	99.8
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	410,000.00	400,000.00	10,000.00	97.6
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	809,190,400.00	808,836,876.07	353,523.93	-
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	809,190,400.00	808,836,876.07	353,523.93	-
131001	Улсын төсвөөс санхүүжих	809,190,400.00	808,836,876.07	353,523.93	-
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	17	17	-	100.0
620001	Удирдах ажилтан	1	1	-	100.0
620002	Гүйцэтгэх ажилтан	14	14	-	100.0
620003	Үйлчлэх ажилтан	2	2	-	100.0

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл
НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН		7,878,773,000.00
УРСГАЛ ЗАРДАЛ		7,878,773,000.00
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ		7,610,801,883.00
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж		7,610,801,883.00
Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж		7,610,801,883.00
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ		267,971,117.00
Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, төвлөрүүлэх шилжүүлэг		267,971,117.00
ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР		7,878,773,000.00
ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС		420,000.00
Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих		420,000.00
Нэмэлт санхүүжилтийн орлого		7,878,353,000.00
Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө		7,878,353,000.00
НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)		

Гурав. Аудитын илрүүлэлт:

Аудитаар нийт 1,769,352.6 мянган төгрөгийн зөрчил илэрснээс, 5,060.0 мянган төгрөгийн зөрчилд 1 төлбөрийн акт тогтоож, 1,764,292.6 мянган төгрөгийн зөрчлийг арилгах 9 албан шаардлага хүргүүлж, зөрчлийг давтан гаргахгүй байх 1 зөвлөмж өгсөн.

Аудитаар илэрсэн 1,769,352.6 мянган төгрөгийн зөрчил нь тогтоосон ерөнхий материаллаг байдлын түвшин 85,505.3 мянган төгрөгөөс өндөр тул **Хязгаарлалттай** дүгнэлт өгсөн.

Дөрөв. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл:

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

	Зөрчлийн товч утга	Үүнээс											
		Нийт зөрчил		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
1	Хоёр ширхэг зөөврийн компьютер байхгүй болсон.	1	5,060.0	1	5,060.0								
2	Байгууллагын ажилчдад бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний хөлс олгосон.	1	7,110.0			1	7,110.0						
3	Анхан шатны баримтын бүрдэлгүй гүйлгээ хийгдсэн. Нягтлан бодогч нь нярвын үүргийг давхар гүйцэтгэдэг.	1	2,038.6			1	2,038.6						
4	ХХОАТ-ыг хугацаанд нь төлөлгүй өр төлбөр үүсгэсэн.	1	2,915.1			1	2,915.1						
5	Өмнөх аудитаар тогтоосон актны төлбөрийг шийдвэрлэх арга хэмжээ авч ажиллаагүй.	1	1,913.9			1	1,913.9						
6	Төсвийг үндэслэлтэй батлуулаагүйгээс ажилтнуудад сүүлийн хагас жилийн үр	1	-			1	-						

	дүнгийн урамшуулал, ээлжийн амралтын цалинг нөхөн олгоогүй.												
7	Зарим арга хэмжээнд зориулж, холбогдох байгууллагуудад олгосон мөнгөн хөрөнгийн зарцуулалтын тайлан, гүйцэтгэл, хүрсэн үр дүн, санхүүгийн баримт тайланг хүлээн авч дүгнээгүй.	1	228,490.0			1	228,490.0						
8	Төсвийн гүйцэтгэлийн тайланг бүрэлдэхүүн хэсгээр иж бүрэн бэлтгээгүй.	1	-					1	-				
9	Босго үнээс давсан худалдан авалтанд нээлттэй сонгон шалгаруулалт явуулаагүй, шууд гэрээ байгуулсан.	1	237,000.0			1	237,000.0						
10	Баяр наадмын арга хэмжээ зохион байгуулахад хувь хүн, хуулийн этгээдүүдтэй босго үнэд багтаан 18.0-20.0 сая төгрөгийн шууд гэрээ байгуулж худалдан авалт хийсэн.	1	1,156,564.0			1	1,156,564.0						
11	Үндэсний их баяр наадмын комисс, Нүүдэлчин монгол их наадмын зочин төлөөлөгчдийн	1	128,261.0			1	128,261.0						

өдрийн хоолны зардлыг хариуцсан.													
Дүн	11	1,769,352.6	1	5,060.0	9	1,764,292.6	1	-					

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Цалингаас бусад 5 сая төгрөгөөс дээш орлого зарлагын гүйлгээг байршуулаагүй.	1	4,057,072.4			1	4,057,072.4		
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
Соёлын яамнаас гүйцэтгэгчийг шууд сонгож, нэг этгээдэд давуу эрх олгон ажил гүйцэтгэх гэрээ байгуулсан.	1	1,858,770.8			1	1,858,770.8		
Дүн	2	5,915,843.2			2	5,915,843.2		